

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2026.05.04

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- МХБ “Хөрвөх чадварыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн хүрээнд Голомт Капитал ҮЦК-тай зах зээл үүсгэгчийн анхны гэрээ байгууллаа.
- Зах зээл үүсгэгч гэж юу вэ?
- Дэлхийн Банк ба Азийн Хөгжлийн Банк Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2026 онд 5.0-5.7% байна гэж таамаглав.
- Экспортын орлого I улиралд өмнөх оны мөн үеэс 62.3 хувиар өсөв.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.15%	-0.37%	-5.65%
MSE A	-0.16%	-0.31%	-5.63%
MSE B	0.91%	0.72%	0.17%

2026/04/27 – 2026/05/01

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
INV	1,241,684,265.00
KHAN	1,021,070,333.00
TDB	256,436,910.00
MSE	226,566,852.69
GLMT	218,377,896.00

2026/04/27 – 2026/05/01

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
MGLA	233.66	15.67%
BBD	120.20	14.99%
MOG	6,840.00	14.96%
OLL	126.00	14.55%
TAND	88.00	14.29%

2026/04/27 – 2026/05/01

2026 он 05-р сарын 04

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,355

ТОП-20 индекс

51,398

MSE A
19,650MSE B
14,386

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

6.8%

2025 - IV улирал

Инфляц

7.4%

2026-03 сар

ГВУН(сая\$)

7,187.76

2026-03 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.1%

USD/MNT

3,576.11

2026-05-03

 Эдийн засгийн мэдээлэл

2026 ОНЫ ЭХНИЙ УЛИРАЛД ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ АШИГТАЙ ГАРЛАА


2026 оны эхний улирлын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны нийт барааны эргэлт 7.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар өссөн байна. Үүнд экспорт огцом нэмэгдэж, 4.9 тэрбум ам.долларт хүрсэн нь жилийн дүнгээр 62.3 хувийн өсөлт үзүүлсэн нь голлон нөлөөлөв. Харин импорт 2.5 тэрбум ам.долларт хүрч, 2.7 хувиар буурсан байна.

Экспортын өсөлтийг голлон уул уурхайн бүтээгдэхүүний нийлүүлэлт болон үнийн өсөлт дэмжсэн байна. Тухайлбал, зэсийн хүдэр, баяжмалын экспорт 1.3 тэрбум ам.доллараар, нүүрс 453.7 сая ам.доллараар, алт 148.8 сая ам.доллараар тус тус өссөн нь нийт экспортын өсөлтийн дийлэнхийг бүрдүүлжээ. Үүнд нүүрсний үнэ тонн тутамд 11.3 ам.доллараар буурсан ч биет хэмжээний өсөлтөөр нөхөгдсөн байна.

Импортын хувьд тээврийн хэрэгсэлтэй холбоотой импорт буурсан нь голлон нөлөөлөв. Тухайлбал, суудлын автомашины импорт 114.5 сая ам.доллар, ачааны автомашин 54.4 сая ам.доллараар тус тус буурсан байна.

Нийт дүнгээр экспортын үнийн таатай орчин, уул уурхайн нийлүүлэлтийн өсөлт болон импортын хязгаарлагдмал өсөлтийн нөлөөгөөр валютын урсгал сайжрах, улмаар гадаад валютын нөөц болон төгрөгийн ханшид эерэг дэмжлэг үзүүлэх суурь нөхцөл бүрдэж байна.

График: Экспорт, импортын өсөлт, бууралт /хувиар/





Зах зээлийн мэдээлэл

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК нь “Хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх тусгай хөтөлбөр”-ийн хүрээнд Голомт Капитал ХХК-тай зах зээл үүсгэгчийн анхны бүртгэл, хамтын ажиллагааны гэрээг байгууллаа. Компани зах зээл үүсгэгчийн үүргийг гүйцэтгэх анхны оролцогч болж байна.




Зах зээл үүсгэгч нь үнэт цаасны арилжаанд худалдан авах, худалдах үнийн саналыг тогтмол байршуулснаар захиалгын биелэлтийг сайжруулах, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнэ тогтоолтыг илүү бодитой, ил тод болгох чухал үүрэгтэй.

2026 оны 1 дүгээр сарын 2-ноос 4 дүгээр сарын 30-ны хооронд МХБ-ийн арилжааны системд нийт 661,151 захиалга бүртгэгдсэнээс ердөө 22.3 хувь нь биелж, 77.7 хувь нь биелээгүй үзүүлэлттэй байна. Энэ нь зах зээл дээрх хөрвөх чадвар сул, захиалгын сангийн гүн хангалтгүй байгааг харуулж байгаа юм.

Ийм нөхцөлд зах зээл үүсгэгчийн тогтолцоог нэвтрүүлэх нь хөрөнгө оруулагчдад үнэт цаасыг бодит үнэд ойр нөхцөлөөр арилжих боломжийг нэмэгдүүлэх, зах зээлийн идэвхийг дэмжих, итгэлийг бэхжүүлэх чухал алхам болж байна. Голомт Капитал ХХК-ийн энэхүү оролцоо нь зах зээл үүсгэгчийн механизмыг бодит арилжаанд хэрэгжүүлэх эхлэл ба цаашдын жишиг болохоор байна.

Цаашид зах зээл үүсгэгчдийн оролцоо нэмэгдэхийн хэрээр захиалгын биелэлт өсөх, арилжааны идэвх сайжрах, үнэ тогтоолт илүү чанартай болох, хөрөнгө оруулагчдын зах зээлд нэвтрэх, гарах нөхцөл хялбарших, улмаар компаниудын хөрөнгө татах орчин илүү үр ашигтай болох юм.

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧ ГЭЖ ЮУ ВЭ?



Зах зээл үүсгэгч нь зах зээл дээр тогтмол **худалдан авах (BID)** болон **худалдах (ASK)** үнийн санал байршуулж, арилжаа тасалдахгүй явагдах нөхцөлийг хангадаг оролцогч юм.

ЯАЖ АЖИЛЛАДАГ ВЭ?

1

Үнийн санал байршуулна

2

Худалдан авагч ба худалдагч холбогдоно

3

Арилжаа явагдана

ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Арилжаа тасалдахгүй

Худалдан авагч эсвэл худалдагч байхгүй үед ч арилжаа явагдана

Хөрвөх чадвар нэмэгдэнэ

Та хүссэн үедээ хувьцаагаа зарж эсвэл авч чадна

Үнийн тогтвортой байдал

Үнийн огцом савлагаа багасч, үнийн зөрүү (spread) багасна




НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР

Зах зээл үүсгэгч нь зах зээлийг **идэвхтэй, хөрвөх чадвартай, тогтвортой** байлгадаг чухал оролцогч юм.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

Ногдол ашигт суурилсан хөрөнгө оруулалт хийхэд мэдэж байх ёстой өдрүүд

Компаниудын хувьцааг эзэмшиж ногдол ашиг авахын тулд доорх өдрүүдийг зайлшгүй мэдэж байх ёстой. Монгол улсын хувьд Т+2 төлбөр тооцооны системийн дагуу гүйлгээ хийгддэг учраас бүртгэлийн өдрөөс 2 хоногийн өмнө тухайн хувьцааг худалдаж аван ногдол ашиг авах боломжтой болдог.

Зарлах өдөр /Declare date/	Хувьцаа авсан байх өдөр /Ex-Dividend date/	Бүртгэлийн өдөр /Record date/	Төлбөрийн өдөр /Payable date/
2026.02.19 өдөр ТУЗ-ийн тогтоолоор зарласан.	2026.03.20 өдөрт амжиж ХЭ болсон байх ёстой.	2026.03.22 өдөр ногдол ашиг авах эрхтэй ХЭ-н жагсаалт гаргана.	2026.04.30 өдөр ҮЦТХТ дансаар олгоно.

Энэ нь ямар нэг компанийн бодит жишээ биш бөгөөд зохиомол өдрүүд болно.